



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 1/2022

Мандалговь

Сургагч багшийн сургалтын  
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.6, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” -ийн 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Чанарын менежментийн тогтолцоог эрчимжүүлэх, тогтолцооны хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Одончимэг, Үйлчилгээний албаны дарга Э.Эрдэнэжаргал нарыг сургагч багшийн сургалтад хамруулсугай.

2. Сургагч багшийн сургалтын зардлын 2,400,000 (хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч (М.Янжиндолгор) -д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4823150365